

“Азийн барометр” олон улсын судалгааны III шат Монгол улсад 2010 оны 4-6 сард явагдаж дууслаа. Уг судалгааны хүрээнд Монгол улс дахь засаглал болон эдийн засгийн өнөөгийн байдлын талаар олон нийтийн санаа бодлыг судалж байгаа бөгөөд өмнөх шатны судалгаа 2003, 2006 онд тус тус явагдсан юм.

Монгол улсыг найман бусэд хувааж түүврээ хийсэн уг судалгаанд 1210 респондент хамрагдсан байна.

Азийн 15 улсад явагддаг энэхүү судалгааны асуулгын 90 орчим хувь нь ижил байдаг бөгөөд Азийн хөгжлийн динамик, тулгарч буй асуудлыг харьцуулан судлах ач холбогдолтой юм.